

**ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД, САНГИЙН САЙДЫН ХАМТАРСАН ТУШААЛ**

2008 оны 01 дүгээр сарын  
30-ны өдөр

Дугаар 21/41

Улаанбаатар хот

Сум /тосгон/, сум дундын эмнэлгийн  
санхүүжилтийн аргачлал батлах тухай

Монгол Улсын Эрүүл мэндийн тухай хуулийн 21.2, 21.4, 28<sup>1</sup>.1, 28<sup>1</sup>.1.7 дахь заалтуудыг үндэслэн ТУШААХ НЬ:

1. Сум /тосгон/, сум дундын эмнэлгийн нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн аргачлалыг нэгдүгээр хавсралтаар, 2008 онд сум /тосгон/, сум дундын эмнэлэгт олгох нийт санхүүжилтийг хоёрдугаар хавсралтаар, нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн аргачлалын бүрэлдэхүүн хэсэг болох үйл ажиллагааны гүйцэтгэлд үндэслэн хуваарилах санхүүжилтийг Эрүүл мэндийн газраас зарцуулах тухай зааврыг гуравдугаар хавсралтаар тус тус баталж, 2008 оны 1 дүгээр сарын 1-нээс эхлэн мөрдсүгэй.

2. Сум /тосгон/, сум дундын эмнэлгүүдийн үйл ажиллагааны гүйцэтгэлийг харгалзан 2008 онд олгох санхүүжилтийг Төрийн сан дахь Эрүүл мэндийн газрын дансанд татан төвлөрүүлж, энэ тушаалын гуравдугаар хавсралтад зааснаар зарцуулан хяналт тавьж ажиллахыг аймаг, нийслэлийн Засаг дарга нарт даалгасугай.

3. Энэхүү тушаалын хэрэгжилтийг ханган, хяналт тавьж ажиллахыг Сангийн яамны Төсвийн бодлого, зохицуулалтын газар /Б.Батжаргал/, Эрүүл мэндийн яамны Санхүү, эдийн засгийн газар /Н.Түмэндэмбэрэл/-т тус тус даалгасугай.

4. Энэ тушаал гарсантай холбогдуулан Эрүүл мэндийн сайд, Сангийн сайдын хамтарсан 2006 оны 1 дүгээр сарын 24-ний өдрийн 16/19 тоот тушаалыг хүчингүй болсонд тооцсугай.

ЭРҮҮЛ МЭНДИЙН САЙД  
  
Б.БАТСЭРЭЭДЭНЭ

САНГИЙН САЙД  
  
Ч.УЛААН



## НЭГ ИРГЭНЭЭР ТООЦСОН САНХҮҮЖИЛТИЙН АРГАЧЛАЛ

### Нэг. Ерөнхий зүйл

- 1.1 Сум /тосгон/, сум дундын эмнэлгүүдийг улсын төсвөөс санхүүжүүлэх зардлын тооцоог хийхэд энэхүү аргачлалыг ашиглана.
- 1.2 Нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн аргын зорилго нь эрүүл мэндийн анхан шатны тусламж үйлчилгээг орон нутгийн хүн амын эрүүл мэндийн хэрэгцээнд үндэслэн тэгш хүртээмжтэй үзүүлэх, тусламж үйлчилгээний чанар, үр дүн, үр ашгийг нэмэгдүүлэхэд санхүүгийн оновчтой хөшүүргийг бүрдүүлэх юм.
- 1.3 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газраас энэ тушаалын хоёрдугаар хавсралтад заагдсан сум /тосгон/, сум дундын эмнэлгүүдийн 2008 оны батлагдсан төсвийн хуваарилалтыг хийхдээ уг аргачлалыг ашиглана.
- 1.4 Аймгийн эрүүл мэндийн газар сум /тосгон/, сум дундын эмнэлгүүдийн төсвийг төлөвлөх, санхүүжилтийг нэг иргэнээр тооцсон аргачлалаар хуваарилах, гүйцэтгэлд хяналт тавьж ажиллах бөгөөд энэ талаар Эрүүл мэндийн Төсвийн ерөнхийлөн захирагчийн өмнө үүрэг хүлээнэ.
- 1.5 Уг тушаалын хоёрдугаар хавсралтаар баталсан сум /тосгон/, сум дундын эмнэлгүүдэд 2008 онд батлагдсан нийт төсвийн санхүүжилтийг хэтрүүлсэн тохиолдолд улсын төсвөөс нэмэлт санхүүжилт олгохгүй бөгөөд үүнтэй холбогдон гарах асуудлыг орон нутгийн засаг захиргаа хариуцна.
- 1.6 Сум /тосгон/, сум дундын эмнэлгийн нийт төсөв гэдэгт энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан нийт төсөв орно. Энэ төсөвт орон нутгийн нэгдсэн эмнэлгийн төсөв орохгүй. Нийслэлийн хувьд дүүргийн эмнэлгүүдийн нийт төсвийн дүнд орж батлагдсан тосгоны эмнэлгүүдийн төсөв орно.
- 1.7 Аймаг, нийслэлийн эрүүл мэндийн газар нь сум /тосгон/, сум дундын эмнэлгүүдийн төсвийг нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн аргачлалаар хуваарилахдаа тухайн эмнэлгийн орон тоо, цалингийн санд хяналт тавьж, бусад эмнэлгүүдтэй харьцуулахад ойролцоо түвшинд байх зарчмыг баримтлана.

### Хоёр. Санхүүжилтийн хуваарилалт

Сум /тосгон/, сум дундын эмнэлгүүдийн батлагдсан төсвийг тус тусад нь энэ аргачлалын дагуу хуваарилна. Энэхүү тушаалын хоёрдугаар хавсралтаар батлагдсан төсвийн дүнд өөрчлөлт орсон тохиолдолд нэмэгдсэн санхүүжилтийг аргачлалын дагуу дахин хуваарилна.

- 2.1 Сум /тосгон/, сум дундын эмнэлгийн нийт төсвийг дөрвөн бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваах

Эхлээд Хоёрдугаар хавсралтын дагуу тухайн аймгийн сум /тосгон/, сум дундын эмнэлэгт батлагдсан нийт төсвийг доор үзүүлсэн аргачлалаар санхүүжилтийн дөрвөн үндсэн бүрэлдэхүүн хэсэгт хуваана. Дараа нь бүрэлдэхүүн хэсэг тус бүрийн нийт дүнг тухайн аймгийн сум /тосгон/, сум дундын эмнэлгүүдэд хуваарилна.

Хүснэгт 1. Нийт санхүүжилтийг бүрэлдэхүүн хэсгүүдэд хуваарилах

№	Санхүүжилтийн бүрэлдэхүүн хэсгүүд	Хуваарилалтын аргачлал
1	Тогтмол зардлын санхүүжилт	Өнгөрсөн оны гүйцэтгэлийг болон бодит өөрчлөлтийг үндэслэнэ
2	Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээг харгалзан нэг иргэнээр тооцон олгох санхүүжилт	Нийт төсвөөс тогтмол зардлын санхүүжилтийг хасч үлдсэн дүнг 0.75-аар үржүүлнэ
3	Алслагдсан байдлыг тооцон нэг иргэнээр тооцон олгох санхүүжилт	Нийт төсвөөс тогтмол зардлын санхүүжилтийг хасч үлдсэн дүнг 0.20-аар үржүүлнэ
4	Үйл ажиллагааны гүйцэтгэлийг харгалзан олгох санхүүжилт	Нийт төсвөөс тогтмол зардлын санхүүжилтийг хасч үлдсэн дүнг 0.05-аар үржүүлнэ

2.2 Бүрэлдэхүүн тус бүрээр хуваарилсан санхүүжилтийг сум /тосгон/, сум дундын эмнэлгүүдэд хуваарилах

**Тогтмол зардлын санхүүжилт.** Тогтмол зардал гэдэг нь тухайн сум /тосгон/-ы хүн амын тооноос үл хамааран гарах зардал буюу уг журмын хүрээнд гэрэл цахилгаан, түлш, халаалт, цэвэр, бохир усны хэрэглээнд зарцуулах зардлыг хэлнэ. Тогтмол зардлыг өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн тогтооно. Өөрөөр хэлбэл, 2008 онд Дорнод аймгийн Баяндун суманд тогтмол зардлын санхүүжилтийг хуваарилахдаа тус сумын эмнэлэгт 2007 онд 2,341.4 мянган төгрөгийг гэрэл цахилгаан, түлш, халаалт, цэвэр, бохир усны зардалд зарцуулсан гэж үзвэл үнэ тариф, хөрөнгө оруулалтын болон холбогдох бусад өөрчлөлтийг тусгаж 2008 оны төсвийн хуваарилалтыг хийнэ. Жишээлбэл, дулааны хэрэгслийг шинэчлэх, ашиглалтын талбайн хэмжээ өөрчлөгдөх гэх мэт.

**Хүн амын эрүүл мэндийн хэрэгцээг харгалзан нэг иргэнээр тооцон олгох санхүүжилт.** Энэ бүрэлдэхүүн хэсэгт нийт төсвөөс тогтмол зардлын санхүүжилтийг хасч үлдсэн дүнг 0.75-аар үржүүлсэн санхүүжилтийг сум /тосгон/, сум дундын эмнэлгүүдэд хуваарилна. Ийнхүү хуваарилахдаа тухайн сум /тосгон/-ын хүн амын тоо болон эрүүл мэндийн хэрэгцээг харгалзан үзнэ. Эрүүл мэндийн хэрэгцээ гэсэн хүчин зүйлийг илэрхийлэгч үндсэн үзүүлэлт нь хүн амын нас, хүйсний ангилал бөгөөд тухайлбал, 0-5 насны хүүхэд болон 60-аас дээш насны хүмүүс бусад бүлэгтэй харьцуулахад илүү тусламж үйлчилгээг шаардана. Иймээс эдгээр насны хүн ам олонтой сум /тосгон/-д харьцангуй илүү санхүүжилт авах ёстой. Үүний тулд насны ангилал тус бүрийн санхүүжилтийн харьцааг тогтоох хэрэгтэй. Санхүүжилтийн харьцааг насны ангилал тус бүрийн эрүүл мэндийн хэрэгцээ буюу сум /тосгон/, сум дундын эмнэлгээс үзүүлж буй тусламж, үйлчилгээний харьцангуй хэмжээг үндэслэн тогтооно.

Энэ бүрэлдэхүүн хэсэгт тооцсон санхүүжилтийн дүнг тухайн аймгийн сум /тосгон/, сум дундын эмнэлгүүдэд хуваарилахын тулд эхлээд сүүлийн 3 жилийн дундаж хүн амын тоог авч Хүснэгт 2-д заасан насны ангилал тус бүрийн эрүүл мэндийн

хэрэгцээний харьцаагаар үржүүлэн жигнэсэн хүн амын тоог гаргана. Хүн амын тоог аймгийн статистикийн албаны мэдээллийг үндэслэн тогтооно. Үүний дараа, аймгийн нийт жигнэсэн хүн амын тоонд сум /тосгон/ тус бүрийн жигнэсэн хүн амын эзлэх хувийг гаргана. Ингээд хувь тус бүрээр энэ бүрэлдэхүүн хэсэгт тооцсон тухайн аймгийн нийт дүнг үржүүлэн сум /тосгон/, сум дундын эмнэлэг тус бүрд ногдох санхүүжилтийг гаргана.

Хүснэгт 2. Тусламж, үйлчилгээний хэрэгцээнд үндэслэсэн санхүүжилтийн харьцаа

Хүн амын насны ангилал	Санхүүжилтийн харьцаа
0-5 нас хүртэлх хүүхэд	2.81
5-16 нас хүртэлх хүүхэд	1.21
16-59 насны эмэгтэй	1.75
16-59 насны эрэгтэй	1.00
60-аас дээш насны хүмүүс	3.92

Уг харьцааг Эрүүл мэндийн яамнаас сум /тосгон/, сум дундын эмнэлгээр үйлчлүүлэгсдийн судалгааг үндэслэн 3 жил тутамд шинэчлэн боловсруулж тогтооно.

**Алслагдсан байдлыг харгалзан нэг иргэнээр тооцон олгох санхүүжилт.** Энэ бүрэлдэхүүн хэсэгт нийт төсвөөс тогтмол зардлын санхүүжилтийг хасч үлдсэн дүнг 0.20-аар үржүүлсэн санхүүжилтийг сум /тосгон/, сум дундын эмнэлгүүдэд хуваарилна. Аймгийн төвөөс алслагдсан сум /тосгон/-дад үзүүлэх тусламж үйлчилгээний зардал аймгийн төвд ойрхон сумдтай харьцуулахад өндөр байдаг тул санхүүжилтийг хуваарилахдаа энэ байдлыг харгалзана. Үүний тулд сум /тосгон/ тус бүрийн аймгийн төвөөс алслагдсан байдлыг километрээр гаргаад нийт дүнг тухайн аймгийн сум /тосгон/-дын тоонд хувааж дундаж зайг олно. Аймгийн төвөөс тухайн сум /тосгон/ хүртэлх зайг дундаж зайнд харьцуулах замаар сум /тосгон/ тус бүрийн аймгийн төвөөс алслагдсан байдлыг харуулах харьцангуй зай хэмээх үзүүлэлтийг гаргаж авна. Харьцангуй зайг сум /тосгон/ тус бүрийн санхүүжилтийн харьцаагаар жигнэсэн хүн амын тоогоор үржүүлэн зайг тооцож жигнэсэн хүн амын тоог гаргана. Дараа нь тухайн сум /тосгон/-ын зайг тооцож жигнэсэн хүн амын тоог аймгийн зайг тооцож жигнэсэн хүн амын нийт тоонд хувааж тус бүрийн эзлэх хувийг гаргана. Эцэст нь энэ бүрэлдэхүүн хэсэгт хуваарилах санхүүжилтийн дүнг сум /тосгон/ тус бүрийн хувиар үржүүлэх замаар сум /тосгон/, сум дундын эмнэлэг тус бүрт ногдох алслагдсан байдлыг харгалзан нэг иргэнээр тооцон олгох санхүүжилтийг гаргана.

**Үйл ажиллагааны гүйцэтгэлийг үндэслэн олгох санхүүжилт.** Энэ бүрэлдэхүүн хэсэгт нийт төсвөөс тогтмол зардлын санхүүжилтийг хасч үлдсэн дүнг 0.05-аар үржүүлсэн санхүүжилтийг сум /тосгон/, сум дундын эмнэлгүүдэд хуваарилна. Уг бүрэлдэхүүн хэсгийн үндсэн зорилго нь сум /тосгон/, сум дундын эмнэлгийн эмч, ажилчдад гүйцэтгэлийн зорилтот үзүүлэлтүүдийг тогтоон өгч тэдгээрийг хангасан тохиолдолд санхүүжилтийг олгоход оршино. Үүнд Эрүүл мэндийн сайдын 2007 оны 301 тоот тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний журам”, “Эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийн багц”-ын анхан шатны тусламж, үйлчилгээнд хамаарах шалгуур үзүүлэлтийг ашиглана.

Гүйцэтгэлд үндэслэсэн санхүүжилтийг тооцохын тулд эхлээд сум /тосгон/, сум дундын эмнэлэг бүрийн тогтмол зардлын санхүүжилт, хүн амын эрүүл мэндийн хэрэгцээг харгалзан нэг иргэнээр тооцон олгох санхүүжилт болон алслагдсан байдлыг харгалзан нэг иргэнээр тооцон олгох санхүүжилтийн нийлбэрийг гаргана. Дараа нь уг нийлбэрийг аймгийн нийт дүнд харьцуулж гаргасан хувиар үйл ажиллагааны гүйцэтгэлийг харгалзан олгох санхүүжилтийн дүнг үржүүлж тухайн сум /тосгон/, сум дундын эмнэлэгт хуваарилах санхүүжилтийг гаргана.

Эрүүл мэндийн газраас сум /тосгон/, сум дундын эмнэлгийн үйл ажиллагааны гүйцэтгэлд үндэслэн хуваарилах санхүүжилтийг уг тушаалын гуравдугаар хавсралтаар батлагдсан зааврын дагуу зарцуулна.

### 2.3. Нэг иргэнээр тооцсон санхүүжилтийн аргачлалын жишээ

“Дорнод” аймаг нийт 13 сумтай, 2008 онд хуваарилах нийт төсөв нь 1,779,916 мянган төгрөг, аймгийн сум /тосгон/, сум дундын эмнэлгийн 2008 оны тогтмол зардлын нийт дүн 178,323 мянган төгрөгөөр батлагдсан гэж үзье.

#### 1. Төсвийн өгөгдөл

Дорнод аймгийн сум /тосгон/ сум дундын эмнэлгийн нийт төсөв (мян.төг)	1,779,916
---	-----------

Төсвийн бүрэлдэхүүн хэсгүүд	Тогтмол зардлын санхүүжилт	Нэг иргэнээр тооцсон санхүүжилт	Алслагдсан байдлыг тооцсон санхүүжилт	Гүйцэтгэл ийн санхүүжилт	Дүн
%		75%	20%	5%	100%
Дүн	178,323	1,201,194	320,318	80,080	1,779,916

**2. Сумын түвшний тоон  
егөгдөл**

Дорнод аймгийн сумд	Баян дун	Баян түмэн	Баян уул	Булгак	Гурван Загал	Даш балсар	Матад	Сэр гэлэн	Халх гол	Хөлен буйр	Цогт овоо	Чулуун хороот	Чой балсан	Дүн
Газар нутгийн хэмжээ ('000 га)														
Сумын төвөөс аймгийн төв хүртэлх зай (км)	176	10	190	50	126	188	143	65	321	127	116	247	55	1,814
Үйлчлүүлэгчдийн ангилал:														
0-5 нас хүртэлх хүүхэд	282	140	453	154	111	316	249	191	249	126	379	139	263	3,053
5-16 нас хүртэлх хүүхэд	677	436	1,086	471	360	766	552	559	642	413	873	331	667	7,834
16-59 насны эмэгтэй	884	598	1,396	635	458	1,024	728	677	924	580	1,042	491	908	10,345
60-сдээш насны хүмүүс	140	121	279	105	57	192	114	116	109	97	175	72	150	1,726
Бусад	1,815	1,245	2,835	1,254	872	2,109	1,491	1,348	1,950	1,145	2,069	938	1,796	20,866
3 жилийн дунджаар Нийт Хүн ам	3,797	2,540	6,049	2,620	1,857	4,408	3,134	2,891	3,874	2,360	4,539	1,972	3,784	43,824

**Санхүүжилтийн харьцаа**

Хүн амын насны ангилал	Санхүүжилтийн харьцаа
0-5 нас хүртэлх хүүхэд	2.81
5-16 нас хүртэлх хүүхэд	1.21
16-59 насны эмэгтэй	1.75
16-59 насны эрэгтэй	1.00
60-с дээш насны хүмүүс	3.92

Санхүүжилтийн харьцаагаар жигнэсэн хүн ам

	Баян дун	Баян түмэн	Баян уул	Булган	Гурван Загал	Даш балбар	Матад	Сэр гэлэн	Халх гол	Хөлөн буйр	Цогт овоо	Чулуун хороот	Чой балсан	Дүн
0-5 нас хүртэлх хүүхэд	792	395	1,275	433	313	889	699	537	701	353	1,067	391	740	8,584
5-16 нас хүртэлх хүүхэд	821	528	1,316	571	436	928	669	678	779	500	1,058	401	809	9,495
16-59 насны эмэгтэй	1,543	1,045	2,439	1,108	799	1,788	1,272	1,182	1,614	1,013	1,820	858	1,585	18,068
60-сдээш насны хүмүүс	547	474	1,093	413	222	754	445	455	426	379	684	283	589	6,765
Бусад	1,815	1,245	2,835	1,254	872	2,109	1,491	1,348	1,950	1,145	2,069	938	1,796	20,866
<b>Санхүүжилтийн харьцаагаар жигнэсэн хүн амын нийт дүн</b>	<b>5,518</b>	<b>3,686</b>	<b>8,958</b>	<b>3,780</b>	<b>2,642</b>	<b>6,468</b>	<b>4,577</b>	<b>4,199</b>	<b>5,469</b>	<b>3,390</b>	<b>6,699</b>	<b>2,871</b>	<b>5,519</b>	<b>63,778</b>

3. Бүрэлдэхүүн хэсгүүдийн Төсвийн тооцоо

	Баян дун	Баян түмэн	Баян уул	Булган	Гурван Загал	Даш балбар	Матад	Сэр гэлэн	Халх гол	Хөлөн буйр	Цогт овоо	Чулуун хороот	Чой балсан	Дүн
<b>1. Тогтмол зардлын санхүүжилт (мян.төг)</b>	<b>792</b>	<b>395</b>	<b>1,275</b>	<b>433</b>	<b>313</b>	<b>889</b>	<b>699</b>	<b>537</b>	<b>701</b>	<b>353</b>	<b>1,067</b>	<b>391</b>	<b>740</b>	<b>8,584</b>

2. Нэг иргэнээр тооцсон санхүүжилт (мян.төг)

	Баян дун	Баян түмэн	Баян уул	Булган	Гурван Загал	Даш балбар	Матад	Сэр гэлэн	Халх гол	Хөлөн буйр	Цогт овоо	Чулуун хороот	Чой балсан	Дүн
Санхүүжилтийн харьцаагаар жигнэсэн хүн амын эзлэх хувь	8.7%	5.8%	14.0%	5.9%	4.1%	10.1%	7.2%	6.6%	8.6%	5.3%	10.5%	4.5%	8.7%	100.0%
Нэг иргэнээр тооцон хуваарилах төсөв (мянган төгрөг)	103,932	69,431	168,709	71,190	49,768	121,827	86,206	79,088	103,008	63,847	126,169	54,079	103,940	1,201,194

3. Алслагдсан байдлыг харгалзсан санхүүжилт (мян.төг)	Баян дун	Баян түмэн	Баян уул	Булган	Гурван Загал	Даш балбар	Матад	Сэр гэлэн	Халх гол	Хөлөн буур	Цогт овоо	Чулуун хороот	Чой балсан	Дун
Сумын төвөөс аймгийн төв хүртэлх зай (км)	176	10	190	50	126	188	143	65	321	127	116	247	55	
Сумын төвөөс аймгийн төв хүртэлх дундаж зай (км)	1.3	0.1	1.4	0.4	0.9	1.3	1.0	0.5	2.3	0.9	0.8	1.8	0.4	140
Харьцангуй хэмжээ	4,789	182	8,237	939	1,677	5,938	3,212	1,347	8,913	2,148	3,773	3,490	1,492	46,136
Зайг тооцож жигнэсэн хүн ам	10.4%	0.4%	17.9%	2.0%	3.6%	12.9%	7.0%	2.9%	19.3%	4.7%	8.2%	7.6%	3.2%	100.0%
Зайг тооцож хуваарилах төсөв (мянган төгрөг)	33,251	1,264	57,189	6,517	11,644	41,230	22,299	9,349	61,880	14,911	26,196	24,232	10,356	320,318


4. Гүйцэтгэлийн санхүүжилт (мян.төг)	Баян дун	Баян түмэн	Баян уул	Булган	Гурван Загал	Даш балбар	Матад	Сэр гэлэн	Халх гол	Хөлөн буур	Цогт овоо	Чулуун хороот	Чой балсан	Дун
Дээрх 3 бүрэлдэхүүн хэсгийн нийлбэр (мянган төгрөг)	139,524	75,032	242,574	89,547	72,496	178,673	121,785	100,817	203,721	90,814	167,405	90,091	127,356	1,699,836
Гүйцэтгэлд үндэслэн олгох төсөв	6,573	3,535	11,428	4,219	3,415	8,417	5,737	4,750	9,597	4,278	7,886	4,244	6,000	80,080

2008 оны нийт төсөв	Баян дун	Баян түмэн	Баян уул	Булган	Гурван Загал	Даш балбар	Матад	Сэр гэлэн	Халх гол	Хөлөн буур	Цогт овоо	Чулуун хороот	Чой балсан	Дун
Нэг хүнд ногдох нэг иргэнээр тооцсон тариф (төг)	146,097	78,567	254,002	93,766	75,911	187,090	127,522	105,567	213,319	95,092	175,292	94,335	133,356	1,779,916
	38,477	30,932	41,988	35,793	40,871	42,447	40,690	36,520	55,059	40,299	38,622	47,845	35,239	40,615



**Гурав. Бусад**

Сум дундын эмнэлэг иргэдэд нэмэлт тусламж, үйлчилгээний багцын тусламж, үйлчилгээ үзүүлсэн тохиолдолд эрүүл мэндийн даатгалын сангаас санхүүжигдэнэ.




**2008 онд сум /тосгон/, сум дундын эмнэлэгт хуваарилах нийт санхүүжилт**

(мян.төг)

Д/д	Аймгийн нэр	Сум /тосгон/-ын эмнэлгүүдийн нийт төсөв	Сум дундын эмнэлгүүдийн нийт төсөв
1	Архангай	2,200,812.5	398,499.0
2	Баян Өлгий	1,661,110.7	724,192.6
3	Баянхонгор	2,273,262.1	500,517.8
4	Булган	1,751,395.2	419,389.0
5	Говь Алтай	1,929,885.2	492,613.5
6	Дорноговь	1,184,036.4	138,502.4
7	Дорнод	983,256.4	449,113.0
8	Дундговь	1,250,533.8	371,350.6
9	Завхан	2,115,976.5	397,018.3
10	Өвөрхангай	2,438,609.9	192,661.5
11	Өмнөговь	1,351,952.8	119,031.8
12	Сүхбаатар	1,516,333.6	152,445.3
13	Сэлэнгэ	1,740,417.9	390,309.7
14	Төв	2,829,302.9	
15	Увс	2,486,102.3	184,044.3
16	Ховд	1,741,401.1	147,077.5
17	Хөвсгөл	2,531,463.3	812,728.2
18	Хэнтий	1,900,642.7	440,924.5
19	Дархан Уул	870,808.1	
20	Орхон	151,985.7	
21	Говьсүмбэр	218,400.8	
22	Улаанбаатар*	553,132.6	

\*- Гачуурт, Хонхор, Туул, Жаргалант тосгоны эмнэлгүүдийн төсөв Нийслэлийн дүүргийн эмнэлгүүдийн нийт санхүүжилтийн дүнд орж батлагдсан болно.



**Үйл ажиллагааны гүйцэтгэлд үндэслэн хуваарилах санхүүжилтийг зарцуулах заавар**

**Нэг. Ерөнхий зүйл**

Үйл ажиллагааны гүйцэтгэлд үндэслэн хуваарилах санхүүжилт нь аймгийн сум /тосгон/, сум дундын эмнэлгийн батлагдсан төсвөөс нийт тогтмол зардлыг хассан дүнг 0.05-аар үржүүлсэн санхүүжилтийн дүн байна.

Аймгийн эрүүл мэндийн газар нь 2007 онд мөрдөж байсан сум /тосгон/, сум дундын эмнэлгийн санхүүжилтийн арга өөрчлөгдсөнтэй холбоотойгоор гарч болох эрсдлийг тооцон, батлагдсан нийт төсөвт багтаан зохицуулалт хийхдээ энэхүү зааврыг баримтална.

**Хоёр. Санхүүжилтийн зохицуулалт**

Үйл ажиллагааны гүйцэтгэлийг харгалзан олгох санхүүжилтийг Аймгийн эрүүл мэндийн газар дараах зорилгоор ашиглана. Үүнд:

- Сум /тосгон/, сум дундын эмнэлгүүдийн үйл ажиллагааны гүйцэтгэлийн зорилтот үзүүлэлтүүдийн дагуу үнэлгээ хийж хангасан тохиолдолд санхүүжилтийг олгох.  
 Үүнд Эрүүл мэндийн сайдын 2007 оны 301 тоот тушаалаар батлагдсан “Эрүүл мэндийн салбарын хяналт-шинжилгээ, үнэлгээний журам”, “Эрүүл мэндийн байгууллагуудын гүйцэтгэлийн үнэлгээний шалгуур үзүүлэлтийн багц”-ын анхан шатны тусламж, үйлчилгээнд хамаарах шалгуур үзүүлэлтийг ашиглана.
- Санхүүжилтийн аргачлалыг шинэчилсний улмаас өмнөх оны төсвийн гүйцэтгэлтэй харьцуулахад гарах хэлбэлзлийг (өсөлт, бууралт) зохицуулах.  
 Тухайн нэг сумын эмнэлгийн 2008 оны төсөв нь өмнөх онтой харьцуулахад харьцангуй өсөхөөр бол энэ эмнэлэгт хуваарилагдах үйл ажиллагааны гүйцэтгэлд суурилсан санхүүжилтийг олгохгүйгээр төсөв нь буурч байгаа бусад сумдын эмнэлэгт олгож болно.
- Хүн амд эмнэлгийн анхан шатны тусламж, үйлчилгээг хэвийн үзүүлэх үүднээс байгалийн болон бусад эрсдэлт хүчин зүйл (тогтмол зардлын өсөлт)-ийн улмаас санхүүгийн тайлангаар өртэй гарсан сум /тосгон/, сум дундын эмнэлэгт олгох.
- Тухайн нэг сум /тосгон/-ын харъяаллын иргэн аймгийн өөр нэгэн сум /тосгон/, сум дундын эмнэлэгт анхан шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан тохиолдолд санхүүжилтийг шилжүүлэн зохицуулах.

Жишээ нь: Дорнод аймгийн Баяндун сумын 5 иргэн Булган суманд отор нүүдэл хийн 3 сар амьдарчээ. Булган суманд амдарч байх хугацаанд сумын эмнэлгээс анхан шатны тусламжийг авсан тохиолдолд Баяндун сумын эмнэлгийн Үйл ажиллагааны гүйцэтгэлийг харгалзан олгох дүнгээс дараах санхүүжилтийг Булган сумын эмнэлэгт шилжүүлнэ.

Дорнод аймгийн сумд	Баяндун	Баянтүмэн	Баянуул	Булган	Гурван Загал
Нэг хүнд ногдох нэг иргэнээр тооцсон тариф (төгрөг)	38,477	30,932	41,988	35,793	40,871
Нэг иргэнд ногдох нэг сарын санхүүжилтийн жишиг хэмжээ (төгрөг)	3,206 (38,477/12)	2,578 (30,932/12)	3,499 (41,988/12)	2,983 (35,793/12)	3,406 (40,871/12)
Нэг иргэний 3 сарын санхүүжилтийн дүн	9,619 (3,206 x 3)	7,733 (2,578 x 3)	10,497 (3,499 x 3)	8,948 (2,983 x 3)	10,218 (3,406 x 3)

Баяндун сумын Үйл ажиллагааны гүйцэтгэлд үндэслэн олгох төсвийн санхүүжилтээс Булган сумын эмнэлэгт шилжүүлэх 5 иргэний 3 сарын санхүүжилт болох 48,096 (9619 x 5) төгрөгийг шилжүүлнэ.

- Тухайн нэг аймгийн сум /тосгон/-ы харъяаллын иргэн өөр нэг аймгийн сум /тосгон/, сум дундын эмнэлэгт анхан шатны эмнэлгийн тусламж, үйлчилгээ авсан тохиолдолд, тусламж, үйлчилгээ үзүүлсэн аймгийн эрүүл мэндийн газарт нэг иргэнээр тооцсон санхүүжилтийг шилжүүлэн олгоно.
- Аймгийн сум /тосгон/, сум дундын эмнэлгийн хэвийн үйл ажиллагааг хангах үүднээс уг санхүүжилтийг сум /тосгон/ хооронд шилжүүлэн ашиглаж болно.

Үйл ажиллагааны гүйцэтгэлийг харгалзан олгох санхүүжилтийг Аймгийн эрүүл мэндийн газар дараах зорилгоор ашиглахыг хориглоно. Үүнд:

- Сум /тосгон/-ы харъяаллын иргэн тухайн аймгийн эсвэл өөр нэгэн аймгийн сум /тосгон/-ы нутаг дэвсгэрт оршин суух хугацаандаа анхан шатны тусламж, үйлчилгээ аваагүй тохиолдолд.
- Энэхүү зааварт зааснаас бусад зориулалтаар ашиглах.